



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 4/201

Улаанбаатар хот

МУБИС-ийн Эрдмийн болон Хүндэт цол
олгох журмыг шинэчлэн батлах тухай

МУБИС-ийн дүрмийн 4.6.2, МУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн ажиллах журмын 6.7 дахь заалт, Эрдмийн зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хурлын шийдвэр, Ректорын зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. МУБИС-ийн Эрдмийн болон Хүндэт цол олгох шинэчилсэн журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор (Б.Хоролдагва)-т үүрэг болгосугай.

РЕКТОР



Ж.БАТБААТАР

20251286



МУБИС-ИЙН ЭРДМИЙН БОЛОН ХҮНДЭТ ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Дээд боловсролын тухай хууль, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан А/210 дугаар тушаалын хавсралт, МУБИС-ийн дүрэм, МУБИС-ийн эрдмийн зөвлөлийн ажиллах журмыг тус тус үндэслэн эрдмийн болон хүндэт цол олгохыг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. МУБИС-ийн дэд профессор, профессор нь эрдмийн цолд, эмерит профессор, хүндэт профессор, хүндэт доктор, бүрэлдэхүүний (салбар) сургуулийн хүндэт профессор нь хүндэт цолд тус тус хамаарна. (Энэ журамд дурдагдах эрдмийн болон хүндэт цолыг цаашид МУБИС-ийн гэж ойлгоно.)

ХОЁР. ЭРДМИЙН ЦОЛ ОЛГОХ ШАЛГУУР

- 2.1. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад үр бүтээлтэй ажилласан, эрдэм шинжилгээний дорвитой бүтээл туурвисан, докторын зэрэгтэй, дэд профессор цолтой дараах шалгуурыг хангасан МУБИС-ийн багш, ажилтанд профессор цол олгоно.
- 2.1.1. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 15-аас цөөнгүй жил ажилласнаас 10-аас цөөнгүйд нь МУБИС-д үндсэн багшаар ажилласан, дэд профессор цол хүртээд 5-аас цөөнгүй жил болсон байх;
- 2.1.2. Дэд профессор цол хүртсэнээс хойш нэг сэдэвт бүтээл, их сургуулийн суралцагчдад зориулсан сурах бичиг тус тус хэвлүүлсэн байх;
- 2.1.3. МУБИС-д хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний сэтгүүлд 10-аас цөөнгүй өгүүлэл нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор, эдгээрээс 5-аас цөөнгүй нь дэд профессор цол хүртсэнээс хойш хэвлүүлсэн байх; Үүнд:
- 2.1.3.1. Байгалийн ухаан, анагаах ухаан, техник, технологийн ухаан, хөдөө аж ахуйн чиглэлийн багш, ажилтан "Web of Science" эсвэл "Scopus" мэдээллийн санд бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор 5-аас цөөнгүй өгүүлэл МУБИС-ийн нэр дээр, эдгээрээс 2-оос цөөнгүй нь дэд профессор цол хүртсэнээс хойш хэвлүүлсэн байх;
- 2.1.3.2. Нийгмийн ухаан, урлаг хүмүүнлэгийн чиглэлийн багш, ажилтан "Web of Science" эсвэл "Scopus" мэдээллийн санд бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор дэд профессор цол хүртсэнээс хойш МУБИС-ийн нэр дээр өгүүлэл хэвлүүлсэн байх;
- 2.1.4. Хоёроос цөөнгүй докторантын диссертаци, тэдгээрээс нэгийг нь дэд профессор цол хүртсэнээс хойш бие даан удирдаж хамгаалуулсан байх; Байгалийн шинжлэх ухааны чиглэлийн багш, ажилтны удирдан хамгаалуулсан 6 магистрын дипломын ажлыг энэ заалтын дэд профессор цол хүртсэнээс өмнө удирдан хамгаалуулсан 1 докторын диссертаци дүйцүүлэн тооцож болно.
- 2.1.5. Дэд профессор цол хүртсэнээс хойш эрдэм шинжилгээний хуралд 5-аас

цөөнгүй илтгэл, үүнээс 2-оос цөөнгүйг нь олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн байх;

2.1.6. Дэд профессор цол хүртсэнээс хойш 3-аас цөөнгүй магистрантын дипломын ажил удирдан хамгаалуулсан (Энэ журмын 2.1.4 заалтад тооцсон магистрантыг давхардуулан тооцохгүй) байх;

2.1.7. Докторантын диссертацийн зөвлөх эсвэл шүүмжлэгч, эсвэл 3-аас цөөнгүй магистрантын дипломын шүүмжлэгч хийсэн байх;

2.1.8. Дэд профессор цол хүртсэнээс хойш олон улсын эсвэл улсын хэмжээний 2-оос цөөнгүй судалгааны төсөлт ажлыг удирдан МУБИС-д хэрэгжүүлсэн байх;

2.1.9. Мэргэжлийн их семинар удирдан явуулдаг байх;

2.1.10. Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл, МУБИС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүнээр тус тус ажилласан байх;

2.1.11. Дэд профессор цол хүртсэнээс хойш эрдэм шинжилгээ, сургалт, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр патент, зохиогчийн эрх, ашигтай загварын гэрчилгээний аль нэгийг авсан байх;

2.2. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад үр бүтээлтэй ажилласан, сургалт, эрдэм шинжилгээний ажлын дадлага, туршлагатай докторын зэрэгтэй дараах шалгуурыг хангасан МУБИС-ийн багш, ажилтанд дэд профессор цол олгоно.

2.2.1. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас цөөнгүй жил ажилласнаас 5-аас цөөнгүйд нь МУБИС-д үндсэн багшаар ажилласан, докторын зэрэг хамгаалаад 3-аас цөөнгүй жил болсон байх;

2.2.2. Нэг сэдэвт бүтээл эсвэл их сургуулийн суралцагчдад зориулсан сурах бичиг хэвлүүлсэн байх;

2.2.3. МУБИС-д хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор 6-аас цөөнгүй өгүүлэл хэвлүүлснээс 3-аас цөөнгүй нь докторын зэрэг хамгаалснаас хойш, энэ 3-ын нэг нь "Web of Science" эсвэл "Scopus" мэдээллийн санд бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд МУБИС-ийн нэр дээр байх;

2.2.4. Докторын зэрэг хамгаалснаас хойш эрдэм шинжилгээний хуралд 8-аас цөөнгүй илтгэл, тэдгээрээс 3-аас цөөнгүйг нь олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн байх;

2.2.5. Докторын зэрэг хамгаалснаас хойш 6-аас цөөнгүй магистрантын дипломын ажил эсвэл 1-ээс цөөнгүй докторантын диссертаци удирдаж хамгаалуулсан байх;

2.2.6. Олон улсын эсвэл улсын хэмжээний судалгааны төсөлт ажлыг удирдан МУБИС-д хэрэгжүүлсэн байх;

2.2.7. Мэргэжлийн семинар удирдан явуулдаг байх;

2.2.8. Бүрэлдэхүүн (салбар) сургуулийн эрдмийн зөвлөл (МУБИС-ийн эрдмийн зөвлөл) эсвэл докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр ажилласан байх;

2.2.9. Докторантын диссертацийн зөвлөх эсвэл шүүмжлэгч, эсвэл 2-оос цөөнгүй магистрантын дипломын шүүмжлэгч хийсэн байх;

2.2.10. Эрдэм шинжилгээ, сургалт, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр патент, зохиогчийн эрх, ашигтай загварын гэрчилгээний аль нэгийг авсан байх;

ГУРАВ. ХҮНДЭТ ЦОЛ ШАЛГУУР

3.1. МУБИС-д үр бүтээлтэй ажиллаж өндөр насны тэтгэврээ тогтоолгосон, шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан дараах болзлыг хангасан багшид МУБИС-ийн эмерит профессор цол олгоно. Үүнд:

3.1.1. МУБИС-д 30-аас цөөнгүй жил, үүнээс тус сургуулийн профессор цол хүртээд 10-аас цөөнгүй жил ажилласан байх;

3.1.2. Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл, МУБИС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүнээр 9-өөс цөөнгүй жил тус тус ажилласан байх;

3.1.3. Энэ журмын 2.1.3 ба 2.1.4 шалгууруудыг хангасан байх;

3.2. Эмерит профессор нь олон улсын болон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал удирдах, урилгаар оролцох, мэргэжлийн семинар зохион байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, ахисан түвшний суралцагч болон залуу судлаачдын судалгааны ажил удирдах, зөвлөх, судалгааны ажлаа олон нийтэд түгээх, сурталчлах, МУБИС-ийн дэд бүтцийг ашиглах эрх, үүрэгтэй.

3.3. Эмерит профессор цол олгохыг жилд 1-ээс дээшгүй удаа эрдмийн зөвлөл хэлэлцэх бөгөөд цолд нэр дэвшигчийн тоо 1 байна. Эмерит профессор цолыг профессорын албан тушаалын 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг нэг удаа олгоно.

3.4. Олон улс болон Монгол Улсын боловсрол, шинжлэх ухаан, соёл, урлаг, нийгэм, эдийн засгийн хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан гадаад улсын болон Монгол Улсын иргэнд МУБИС-ийн хүндэт доктор цол олгоно.

3.5. МУБИС-ийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан, сургалт, эрдэм шинжилгээ, материаллаг баазыг бэхжүүлэхэд олон жил идэвх зүтгэл гарган хамтран ажилласан гадаад улсын болон Монгол Улсын нэр хүндтэй эрдэмтэн, судлаачид МУБИС-ийн хүндэт профессор цол олгоно.

3.6. МУБИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн багш, ажилтанд МУБИС-ийн бүрэлдэхүүний (салбар) сургуулийн хүндэт профессор цолыг тухайн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрээр олгоно.

ДӨРӨВ. НЭР ДЭВШИГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

4.1. Эрдмийн цолд нэр дэвшигч дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

4.1.1. Анкет;

4.1.2. Ажил байдлын тодорхойлолт (Эрдмийн цолд нэр дэвшүүлж байгаа үндэслэлийг тодорхой гаргаж, тухайн сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч гарын үсэг зурж баталгаажуулсан байна);

4.1.3. Доктор, магистрын төгсөлтийн ажил удирдаж хамгаалуулсан тухай хамгаалуулах зөвлөлийн тогтоолын хуулбар;

4.1.4. Харьяа тэнхимийн эрхлэгчийн баталгаажуулсан бүтээлийн жагсаалт;

4.1.5. Докторын диплом болон дэд профессорын үнэмлэхийн баталгаажуулсан хуулбар;

4.1.6. Ажилласан хугацааг нотлох баримт;

4.1.7. Мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүний (салбар) сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

4.2. Хүндэт цол олгуулахаар нэр дэвшүүлэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

4.2.1. Нэр дэвшигчийн товч намтар;

4.2.2. Хүндэт цол олгох үндэслэл (харгалзах хүндэт цолын болзлыг хангасан болохыг тоо, баримт, нотолгоотой тодорхой гаргаж, тухайн сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч гарын үсэг зурж баталгаажуулсан байна);

4.2.3. Мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүний болон салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

ТАВ. ЦОЛ ОЛГОХ

5.1. Эрдмийн болон хүндэт цолд нэр дэвшүүлэх асуудлыг мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүний сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шалгуурыг 100 хувь биелүүлсэн гэж үзвэл тухайн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга холбогдох бичиг баримтыг журмын дагуу бүрдүүлэн баталгаажуулж, МУБИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан нэгжид ирүүлнэ.

5.2. МУБИС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг нэр дэвшигч бүрийн шалгуур хангасан байдлыг магадлан хэлэлцэж, эрдмийн зөвлөлийн хуралд оруулах эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ. *(Бүтээлд магадлан шинжилгээ хийхдээ энэхүү журамд заасан үзүүлэлтийн биелэлтийг нотлох баримтаар баталгаажуулан үзнэ)* Ажлын хэсгийн ахлагч нэр дэвшигч шалгуурыг хэрхэн хангасан болохыг эрдмийн зөвлөлийн гишүүдэд хүргэсэн байх ба хуралд дэлгэрэнгүйгээр танилцуулна.

5.3. Эрдмийн болон хүндэт цолд нэр дэвшигч эрдмийн зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн 75-аас доошгүй хувийн дэмжсэн санал авсан тохиолдолд цол олгох шийдвэр гаргаж, эрдмийн зөвлөлийн хурлын тогтоолоор баталгаажуулна.

5.4. Эрдмийн болон хүндэт цол олгохоор шийдвэрлэсэн хүнд харгалзах эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн, батлагдсан загварын үнэмлэх олгоно.

5.5. Эрдмийн цол олгох асуудлыг эрдмийн зөвлөл жилд 2-оос дээшгүй удаа хэлэлцэж болох ба нэг удаагийн хурлаар хэлэлцэх профессор цолд нэр дэвшигчийн тоо 2-оос олонгүй, дэд профессор цолд нэр дэвшигчийн тоо 4-өөс олонгүй байна.

5.6. Эрдмийн болон хүндэт цолын үнэмлэх нэгдсэн дугаартай байх бөгөөд цол олгох ёслолын ажиллагааг эрдэм шинжилгээ хариуцсан нэгж зохион байгуулна.

ЗУРГАА. БУСАД

6.1. Шаардлага хангаагүй, хуурамч баримт бүрдүүлсэн бол материалыг эрдмийн зөвлөлийн гишүүдээс бүрдсэн ажлын хэсгээс буцаах бөгөөд нэр дэвшигч 2 жилийн хугацаанд дахин нэр дэвших эрхгүй. Энэ тохиолдолд хянан магадлагаа хийсэн бүрэлдэхүүний болон салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарт Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

6.2. Шинжлэх ухаан, технологийн санд хадгалагдаж буй эрдэмтдийн мэдээллийн

санд үндэслэн МУБИС-ийн эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нэр дэвшигчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бүтээлийн жагсаалтыг хянан баталгаажуулж, сургуулийн архивт хадгална.

6.3. Эрдмийн болон хүндэт цол олгохтой холбоотой зардлыг шийдвэр гаргагч байгууллага, бүрэлдэхүүний болон салбар сургууль хариуцна.

6.4. Эрдмийн цолд нэр дэвшээд эрдмийн зөвлөлийн гишүүдийн олонхын санал авч чадаагүй бол 1 жилийн хугацаанд дахин нэр дэвших боломжгүй. Хүндэт цолд нэр дэвшээд эрдмийн зөвлөлийн гишүүдийн олонхын санал авч чадаагүй тохиолдолд дахин нэр дэвшүүлэхгүй.

6.5. Эрдмийн болон хүндэт цол олгохтой холбогдсон гомдлыг МУБИС-ийн эрдмийн зөвлөлд эрдэмтэн нарийн бичгийн даргаар уламжлан мэдүүлнэ. Эрдмийн зөвлөлийн даргын томилсон ажлын хэсэг нэг сарын дотор шалгаж, дүнг эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

6.6. Эрдмийн цолыг зохих шаардлага зөрчиж олгосон нь нотлогдвол эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн, ректорын тушаалаар уг шийдвэрийг хүчингүй болгож шалгаруулалтыг зохион байгуулсан эрдмийн зөвлөлийн гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийн ахлагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.